



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/643

Булган сум

Англи хэлний вакумжуулсан сургалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, “Англи хэлтэй Булган хөтөлбөр батлах тухай” VI/33 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд зохион байгуулах англи хэлний багш нарыг мэргэшүүлэх вакумжуулсан сургалтыг Монголын англи хэлний академитай хамтран ажиллах гэрээ байгуулан зохион байгуулж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг “Англи хэлтэй Булган” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010898